



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 101/ШЗ2019/03517

Улаанбаатар хот

Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Ганболд би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, Ньюмайнд групп ХХК-ийн байранд байрлах “Лэндмн” ХХК /РД:5039754/

Хариуцагч: Баянзүрх дүүрэг, 27 дугаар хороо, дунд дарь эх 17-р гудамж, 1272 тоотод оршин суух Хулууд овогт Батчулууны Цэвэлсүрэн /РД: ИН91021801/

179 070 төгрөг гаргуулах төгрөг гаргуулах тухай хэргийг хүлээн авч хянаад,

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч “Лэндмн” ХХК нь шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Б.Цэвэлсүрэнгээс үндсэн зээл 150 000 төгрөг, шимтгэл 14 000 төгрөг, нотариатын үйлчилгээний төлбөр 15 070 төгрөг нийт 179 070 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч “Лэндмн” ХХК нь хариуцагч Б.Цэвэлсүрэнд холбогдуулан 179 070 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.

Хариуцагч Б.Цэвэлсүрэнг шүүхэд ирүүлэхээр “Мэдэгдэх хуудас”-ыг нэхэмжлэлд дурдсан Баянзүрх дүүрэг, 27 дугаар хороо, дунд дарь эх 17-р гудамж, 1272 тоот хаягаар хүргүүлэхэд хариуцагч нь уг хаягт бүртгэлгүй бөгөөд оршин суудаггүй болох нь тус хорооны Засаг даргын тодорхойлолтоор, мөн хаягт ийм хүн байхгүй гэсэн шуудангийн магадлагаагаар тус тус тогтоогдож байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д хариуцагчийн хаяг тодорхойгүй бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана”, мөн хуулийн 117 дугаар зүйлийн 117.1-т “энэ хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д заасан үндэслэл иргэний хэрэг үүсгэснээс хойш...” тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгоно гэж тус тус заажээ.

Иймд хариуцагчийн оршин суугаа хаяг тодорхойгүй байх тул хуулийн дээрх заалтуудыг үндэслэн Б.Цэвэлсүрэнд холбогдох “Лэндмн” ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзэв.

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.1.9, 117 дугаар зүйлийн 117.1-д 123 дугаар зүйлийн 123.1-д заасныг тус тус удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Б.Цэвэлсүрэнд холбогдох “Лэндмн” ХХК-ийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2 . Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д зааснаар нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 452 төгрөгийг Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн 2609006167 тоот данснаас гаргуулж, нэхэмжлэгч тоот “Лэндмн” ХХК-нд буцаан олгосугай.

3. Шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тус шүүхэд гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

ШҮҮГЧ



Д.ГАНБОЛД